



УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2015 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 1793

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын иргэний үнэмлэх хэвлэх, бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах, үнэ хураамжийн тооцоо хийх, хэвлэгдсэн иргэний үнэмлэхийг хүлээн авах, түгээх, тайланг гаргах, түүнд хяналт тавих журам”-ын 4.6, 4.7, 5.1, 6.2, 7.4 дэх заалтуудыг дор дурьдсанаар өөрчилсүгэй. Үүнд:

“4.6. Уг хураагдсан иргэний үнэмлэхийг дагалдах жагсаалт, албан тоотыг үйлдэн, иргэний үнэмлэхийн хамт Санхүүгийн хэлтэст хагас жилд нэг удаа ирүүлнэ.”;

“4.7. Иргэний үнэмлэх авах иргэдийн тоо, нийт хэвлэгдсэн, дахин хүсэлт гаргасан, үүнээс хэвлэгдсэн, засагдаж хэвлэгдсэн тоон мэдээг тухайн аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Нийслэлийн улсын бүртгэлийн газар сар бүр Иргэний бүртгэл, гадаад паспортын газар, Санхүүгийн хэлтэст дараагийн сарын 10-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ. Тоон мэдээг тушаалын 2 дугаар хавсралтын “Тайлан, тоо мэдээний хүснэгт”-ийн 4-т зааснаар гаргана.”;

“5.1. Иргэний үнэмлэхийг хэвлэх горимд мэдээллийг шилжүүлэн баталгаажуулснаар Иргэний үнэмлэх хэвлэлтийн үйлдвэрт онлайнаар ирсэн мэдээллийг үндэслэн иргэний үнэмлэх хэвлэх ба алдаатайн улмаас хэвлэгдээгүй иргэний үнэмлэхийн зөрчлийг холбогдох газраар арилгуулж, дахин хэвлүүлэх ажлыг Мэдээллийн технологийн газар хариуцан гүйцэтгэнэ.


“6.2. Тайланг дараа сарын 5-ны өдрийн дотор факсаар болон албан тоотоор Санхүүгийн хэлтэст ирүүлнэ.”;

“7.4. Аймаг, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, хэлтсээс сар бүр ирүүлсэн тайланг Санхүүгийн хэлтэс шаардагатай мэдээлэлтэй тулган шалгаж, зөрчил илэрсэн тохиолдолд тухай бүр газар, хэлтэстэй нь холбогдож зөрчлийг арилгуулна.

2. Дээрх журмын 5.2, 5.3, 7.3 дахь заалтуудыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг Мэдээллийн технологийн газрын дарга М.Алтанзүрх, Иргэний бүртгэл, гадаад паспортын газрын дарга Д.Энхцэцэг, Санхүүгийн хэлтсийн ахлах нягтлан бодогч Ч.Баасансүрэн нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ

00003240



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 558

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газар агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 16.5.2, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8.1.10, 9.1, Засгийн газрын 2011 оны Монгол Улсын иргэний үнэмлэхийн дүрэм батлах тухай” 338 дугаар тогтоолын 1.11 дэх заалт, Засгийн газрын 2013 оны “Үйлчилгээний хөлснөөс чөлөөлөх тухай” 36 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Монгол Улсын иргэний үнэмлэх хэвлэх бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах, үнэ хураамжийн тооцоо хийх, хэвлэгдсэн иргэний үнэмлэхийг хүлээн авах, түгээх, тайланг гаргах, түүнд хяналт тавих журам”-ыг нэгдүгээр, “Тайлан, тоо мэдээний хүснэгт”-ийг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2.Энэхүү журмын хэрэгжилтыг ханган ажиллахыг Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Алтангэрэл, Иргэний бүртгэлийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чанлуулдой, Бүртгэлийн хяналтын газрын дарга Ц.Ганзориг, Мэдээллийн технологийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Чимэддорж, Хяналт шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Баатарт нарт үүрэг болгосугай.



Ц.ПҮРЭВДОРЖ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын
2013 оны 558 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ ХЭВЛЭХ БҮРТГЭЛ
ХӨТЛӨХ, МЭДЭЭЛЛИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, ҮНЭ ХУРААМЖИЙН
ТООЦОО ХИЙХ, ХЭВЛЭГДСЭН ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХИЙГ ХҮЛЭЭН
АВАХ, ТҮГЭЭХ, ТАЙЛАНГ ГАРГАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зорилго

Монгол Улсын иргэний үнэмлэхийн бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах, иргэний үнэмлэх хэвлэх, хэвлэгдсэн иргэний үнэмлэхийг хүлээн авах, түгээх, тайлан гаргах, үнэ хураамжийн тооцоо хийх, орлогын данстай тулгах, тайлан гаргах, иргэний үнэмлэх хэвлэх явцад зөрчилтэйн улмаас хэвлэгдээгүй иргэний үнэмлэхийг дахин хэвлүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах, хариуцлага тооцоход энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Иргэний үнэмлэхийн бүртгэл хөтлөх

2.1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2013 оны “Монгол Улсын иргэний үнэмлэх олгох, түүнд мэдээлэл оруулах, бүртгэл хөтлөх нарийвчилсан журам” -д нэмэлт өөрчлөлт оруулах тухай 128 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.1 дэх зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн улсын бүртгэгч иргэний үнэмлэхийн бүртгэлийг хөтлөхдөө анх удаа авах, дахин авах, хүчинтэй хугацаа сунгах зэргээр бүртгэлийн дэвтрийг тус тусад нь хөтөлнө.

2.1.2 Дээрх журмын 2.3 дах хэсэгт заасан бүртгэлийн улмаас болон 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө алдаатай хэвлэгдсэн, зөрчилтэй улмаас хэвлэгдээгүй иргэний үнэмлэхийн бүртгэлийн талаарх дэвтрийг мөн хөтөлнө.

2.2 Аймаг, нийслэл, сум, дүүргийн улсын бүртгэгч иргэний үнэмлэх авах хүсэлтийг үнэ төлбөртэй, үнэ төлбөргүйгээр бүртгэсэн бүртгэлийн дэвтэр, үнэ хураамж төлсөн баримтын /үйлчилгээний орлого, улсын тэмдэгтийн хураамж/ хамт улсын ахлах бүртгэгчид тухай бүр хүлээлгэн өгч, баталгаажуулна.

**Гурав. Иргэний үнэмлэхийн мэдээллийг баталгаажуулах,
тайлан гаргах, бүртгэл хөтлөх**

3.1 Аймаг, нийслэл, сум, дүүргийн улсын бүртгэгчийн бүртгэлийн дэвтрийг, үнэ хураамж төлсөн баримт, бусад холбогдох мэдээллийн үнэн зөв байдлыг тулган шалгаж, иргэний үнэмлэхийн мэдээллийг аймаг, нийслэлд улсын ахлах бүртгэгч баталгаажуулна.

3.2 Аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс хүргүүлсэн иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн иргэдийн мэдээллийг Мэдээллийн технологийн газар ажлын 3 хоногийн дотор уншуулна.

3.3 Баталгаажуулсан тайланг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, тайланг, үнэ хураамжийн баримтын хамт тухайн сарын сүүлчийн өдрийн дотор нийслэлд Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгчид, орон нутагт хяналтын улсын байцаагчид тус тус хүлээлгэн өгнө. Тайланг тушаалын 2 дугаар хавсралтын “Тайлан, тоо мэдээний хүснэгт”-ийн 2-т зааснаар гаргана.

3.4 Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч, орон нутагт хяналтын улсын байцаагч тайланг хянаж, дараагийн сарын 3-ны өдрийн дотор тухайн нэгжийн санхүүгийн ажилтанд хүлээлгэн өгнө.

Дөрөв. Хэвлэгдсэн иргэний үнэмлэхийг хүлээн авах,
түгээх, тайлан гаргах

4.1 Хэвлэгдсэн иргэний үнэмлэхийг нийслэлд Нийслэлийн улсын бүртгэлийн газар, орон нутагт тухайн хэлтсийн итгэмжлэгдсэн ажилтан хүлээж авч, сум, хорооны улсын бүртгэгчид дагалдах хуудас, тооцоо нийлж хүлээлгэн өгнө.

4.2 Хэвлэгдсэн иргэний үнэмлэхийг олгохдоо 2013 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс хойш иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан боловч үнэ хураажийн тооцоо хийгдээгүй иргэний үнэмлэхийн тооцоог тухайн аймаг, дүүрэг, сум, хорооны улсын бүртгэгч хариуцаж төлүүлэх үүрэгтэй бөгөөд үнэ хураамжийг төлсөн талаарх мэдээллийг тухай бүрт аймаг, дүүргийн улсын ахлах бүртгэгчид тайлагнана.

4.3 Хүлээн авсан иргэний үнэмлэх болон тараагдсан, тараагдаагүй, үлдэгдлийн тоон мэдээ, судалгааг сум, хорооны бүртгэгч нь аймаг, дүүргийн иргэний үнэмлэх хариуцсан улсын бүртгэгчид долоо хоног бүр хүргүүлнэ. Мэдээг тушаалын 2 дугаар хавсралтын "Тайлан, тоо мэдээний хүснэгт"-ийн 1а-д зааснаар гаргана. Сум, хорооноос ирсэн тоон мэдээний нэгтгэлийг иргэний үнэмлэх хариуцсан улсын бүртгэгч нэгтгэн, улсын ахлах бүртгэгч хянана. Нэгтгэлийн мэдээг тушаалын 2 дугаар хавсралтын "Тайлан, тоо мэдээний хүснэгт"-ийн 1б-д зааснаар гаргана.

4.4 Дээрх нэгтгэсэн тоон мэдээний нэгтгэлийг мөн дараагийн сарын 3-ны өдрийн дотор тухайн нэгжийн санхүүгийн ажилтанд хүлээлгэн өгнө.

4.5 Алдаатай, зөрчлийн улмаас хэвлэгдэж, хураагдсан иргэний үнэмлэхийг нийслэлд Нийслэлийн улсын бүртгэлийн газар, орон нутагт аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нэгтгэн акт үйлдэж, иргэний үнэмлэхийг иргэний нэрээр жагсаалт үйлдэн нэгжийн санхүүгийн ажилтанд улиралд нэг удаа хүлээлгэн өгнө.

4.6 Уг хураагдсан иргэний үнэмлэхийг дагалдах жагсаалт, албан тоотыг үйлдэн, иргэний үнэмлэхийн хамт Хяналт-шинжилгээ, дотоод аудитын болон Санхүү, бүртгэлийн хэлтэст хагас жилд нэг удаа ирүүлнэ.

4.7 Иргэний үнэмлэх авах иргэдийн тоо, нийт хэвлэгдсэн, дахин хүсэлт гаргасан, үүнээс хэвлэгдсэн, зөрчилтэй хэвлэгдсэн, засагдаж хэвлэгдсэн тоон мэдээг тухайн аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Нийслэлийн улсын бүртгэлийн газар нь сар бүр Иргэний бүртгэлийн газар, Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтэст дараагийн сарын 10-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ. Тоон мэдээг тушаалын 2 дугаар хавсралтын "Тайлан, тоо мэдээний хүснэгт"-ийн 4-т зааснаар гаргана.

Тав. Иргэний үнэмлэх хэвлэлтийн давхар хяналт

5.1. Иргэний үнэмлэхийг хэвлэх горимд мэдээллийг шилжүүлэн баталгаажуулснаар Иргэний үнэмлэх хэвлэлтийн хэлтэст онлайнаар ирсэн мэдээллийг үндэслэн иргэний үнэмлэх хэвлэх ба алдаатайн улмаас хэвлэгдээгүй иргэний үнэмлэхийн зөрчлийг холбогдох газраар арилгуулж дахин хэвлүүлэх ажлыг Иргэний үнэмлэх хэвлэлтийн хэлтэс хариуцан гүйцэтгэнэ.

5.2 Алдаатайн улмаас хэвлэгдээгүй иргэний үнэмлэхийн тоо, тухайн иргэний мэдээлэл, зөрчлийн байдал зэргийг Хяналт, шинжилгээ, дотоод аудитын хэлтэст

танилцуулан тус хэлтэс нь тухайн иргэний зөрчлийг арилгуулахаар холбогдох газар, хэлтэст хүргүүлнэ.

5.3. Алдаатайн улмаас хэвлэгдээгүй иргэний үнэмлэхийн зөрчлийг арилгасны дараа тухайн иргэний үнэмлэхийг нэгтгэн хэвлэх горимд мэдээллийг шилжүүлснээр дахин хэвлэнэ.

Зургаа. Үнэ хураамжийн тооцоо хийх

6.1 Тухайн нэгжийн санхүүгийн ажилтан ирүүлсэн тайланг, үнэ хураамж төвлөрсөн данс, түүнд орсон орлогын дүнтэй тулган шалгаж мөн тайланг гаргана. Тайланг тушаалын 2 дугаар хавсралтын “Тайлан, тоо мэдээний хүснэгт”-ийн 3-т зааснаар гаргана.

6.2 Тайланг дараа сарын 5-ны дотор факсаар болон албан тоотоор ерөнхий газрын Хяналт, шинжилгээ, дотоод аудитын болон Санхүү, бүртгэлийн хэлтэст ирүүлнэ.

Долоо. Хяналт тавих

7.1 Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний үнэмлэхийн бүртгэл хөтөлсөн, мэдээллийг баталгаажуулсан байдалд тухайн нэгжийн хяналтын улсын байцаагч хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгах талаар арга хэмжээг авч ажиллана.

7.2 Дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн иргэний үнэмлэхийн бүртгэл хөтөлсөн, мэдээллийг баталгаажуулсан байдалд дүүргийн хяналтын улсын байцаагч, нийслэлийн улсын бүртгэлийн газар хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгах талаар арга хэмжээг авч ажиллана.

7.3 Иргэний үнэмлэх хэвлэлтийн хэлтэст алдаатайн улмаас хэвлэгдээгүй иргэний үнэмлэхийг дахин хэвлүүлэх үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, дотоод аудит хэлтэс хяналт тавина.

7.4 Аймаг, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, хэлтсээс сар бүр ирүүлсэн тайланг Хяналт-шинжилгээ, дотоод аудитын болон Санхүү, бүртгэлийн хэлтэс шаардлагатай мэдээлэлтэй тулган шалгаж, зөрчил илэрсэн тохиолдолд тухай бүр газар, хэлтэстэй нь холбогдож зөрчлийг арилгах, цаашид хэрхэн ажиллах талаар чиглэл өгч ажиллана.

Найм. Хариуцлага

8.1 Аймаг, нийслэл, сум, дүүргийн улсын бүртгэгч иргэний үнэмлэхийн бүртгэлийг хөтөлсөн, үнэ хураамжийг төлүүлсэн, үнэгүй дахин хэвлүүлэхээр бүртгэсэн болон гаргасан тайлангийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.

8.2 Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны улсын бүртгэгч үнэ хураамжийг төлүүлээгүй хэвлэгдсэн иргэний үнэмлэхийн үнэ хураамжийг төлүүлэх үүргийг бүрэн хариуцна.

8.3 Сум, хорооны улсын бүртгэгч хэвлэгдсэн иргэний үнэмлэхийн тараалтын тоо мэдээний үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.

8.4 Аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн, нийслэлийн хяналтын улсын байцаагч тухайн улсын бүртгэгчийн хөтөлсөн бүртгэлийг хянаж, мэдээллийн баталгаажуулалт, тайлангийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.

8.5 Мэдээллийн технологийн газрын Иргэний үнэмлэх хэвлэлтийн хэлтэс алдаатайн улмаас хэвлэгдээгүй иргэний үнэмлэхийг дахин хэвлүүлэх, алдааны мэдээллээс шалтгаалан холбогдох газрууд алдааг засаж, мэдээллийг буцааж баталгаажуулах үйл ажиллагааг бүрэн хариуцна.

8.6 Тухайн нэгжийн санхүүгийн ажилтан тушаасан мөнгөний баримт, дансны орлогын тооцоо, тайлангийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.

8.7 Энэхүү журмыг зөрчсөн бүртгэлийн байгууллагын улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч, хяналтын улсын байцаагч, бусад холбогдох газар, хэлстийн албан хаагч хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

---oOo---

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын
2013 оны 558 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ТАЙЛАН, ТОО МЭДЭЭНИЙ ХҮСНЭГТ

Хүснэгт -1а

.....СУМ, ХОРООНЫ ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХИЙН ТАРААЛТЫН ТООН МЭДЭЭ

20... оны-р сарын-ны өдрөөс 20... оны-р сарын-ны өдрийг хүртэлх

Аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсээс хүлээж авсан иргэний үнэмлэхийн тоо	Иргэний гар дээр очсон иргэний үнэмлэхийн тоо	Үүнээс:		Тараагдаагүй байгаа иргэний үнэмлэхийн тоо	Зөрчилтэйн улмаас хураагдсан иргэний үнэмлэхийн тоо
		Хэвлэгдсний дараа төлүүлсэн иргэний үнэмлэхийн тоо			
1	2	3		4 /1-2/	5

Тайлан гаргасан:

.....Сум, хорооны улсын бүртгэгч..... / овог, нэр/

Хүснэгт-1б

.....АЙМАГ, ДҮҮРГИЙН ТАРААСАН ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХИЙН ТООН МЭДЭЭНИЙ НЭГТГЭЛ

Д/д	Аймгийн сум, нийслэлийн дүүргийн нэр	Хэвлэгдсэн иргэний үнэмлэхийн хүлээн авсан тоо	Тараагдсан иргэний үнэмлэхийн тоо				ДҮН
			Тараасан буюу иргэний гар дээр очсон	Тараагдаагүй	Буруу хэвлэгдсэн	Буруу хэвлэгдснийг буцаасан	
1		2	3	4	5	6	7/+3+4+5+6/
	ДҮН						

Хянасан:

.....Аймаг, дүүргийн улсын ахлах бүртгэгч..... / овог, нэр/

Тайлан гаргасан:

.....Аймаг, дүүргийн улсын бүртгэгч..... / овог, нэр/

Хүлээн авсан:

.....Аймаг, НУБГ-ын нягтлан бодогч..... / овог, нэр/

.....АЙМАГ, ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ
 ҮНЭМЛЭХ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТАЙЛАН

Д/д	Аймгийн сум, нийслэлийн дүүргийн нэр	Эхний үлдэгдэл /Үнд: 2013.01.01-нээс хойш бүртгэл хийгдсэн боловч үнэ хураамжийн тооцоо хийгдээгүй иргэний үнэмлэхийн тоо	Бүртгэлийн тоо /иргэнээр/	Үүнээс:			Үүнээс: үнэтэй, үнэгүй авах иргэний үнэмлэхийн тоо		Үнэ төлбөрийн дүн /төгрөгөөр/	Эцсийн үлдэгдэл
				Анх удаа авах	Дахин авах	Бусад	Үнэ төлбөртэй авах	Үнэ төлбөргүй авах		
1		2	3 /4+5+6/	4	5	6	7	8/8=6/	9 /7x15000 төг/	10 /2+3- 7-8/
	ДҮН									

Тайлан хянасан:

.....Аймаг, дүүргийн хяналтын улсын байцаагч, НБУГ-ын АУБ..... / овог, нэр/

Тайлан гаргасан:

.....Аймаг, дүүргийн улсын ахлах бүртгэгч / овог, нэр/

Хүлээн авсан:

.....Аймаг, НУБГ-ын нягтлан бодогч / овог, нэр/